

**Санхүүгийн тайлан ба Хараат бус
аудиторын тайлан**

**“Говийн оюу хөгжлийг дэмжих
сан” ТББ**

2020 оны 12 дугаар сарын 31



Агуулга

Хараат бус аудиторын дүгнэлт	1
Санхүүгийн байдлын тайлан	3
Үр дүнгийн тайлан	4
Цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан	5
Мөнгөн гүйлгээний тайлан	6
Хараат бус аудиторын Үндэслэлтэй баталгаажуулалтын дүгнэлт	7
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	11



Grant Thornton

“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК

Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний дэлхийн сүлжээний бие даасан фирм

Хараат бус аудиторын дүгнэлт

Далай тауэр, 9 давхар,
ЮНЕСКО гудамж - 31,
Сүхбаатар дүүрэг,
1 хороо Улаанбаатар
14230, Монгол улс
T + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,
UNESCO street - 31,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230,
Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-ын удирдлагад:

Дүгнэлт

Бид “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-ын (цаашид “Төрийн бус байгууллага”) -ын 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материалыг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн баталсан Монгол улсын Сангийн сайдын заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргшэсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Байгууллагаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангальттай, тохиромжтой гэж итгэж байна.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланы хүлээх үүрэг хариуцлага

Төрийн бус байгууллагын удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт (“СТОУС”)-д нийцүүлэн баталсан Сангийн сайдын заавар, журмын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материалыг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Төрийн бус байгууллагын үйл ажиллагааг зогсоох, татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах Төрийн бус байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.


Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр төвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хувалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Төрийн бус байгууллагын дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор буюу тухайн нэхцэл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохицтой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Төрийн бус байгууллагын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нэхцэл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нэхцэл байдал Төрийн бус байгууллага нь тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж, санхүүгийн тайланда үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.
- Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.


ГРАНТ ТОРНТОН
АУДИТ LLC
Б.ОСОРГАРАВ
УДИРДАХ ПАРТНЕР
2021 оны 9 дүгээр сарын 10

Байгууллагын тухай товч МЭДЭЭЛЭЛ

БАЙГУУЛЛАГЫН НЭР: "Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ

УЗ-ИЙН ГИШҮҮД:

Дарга:

Тим Экерсли

Гишүүд:

Х. Сугир

Н. Наранбаатар

Б. Эрдэнэ-Очир

Деррик Хансен

Д. Амарбаясгалан

Г. Сугар

Б. Баяр

АЖЛЫН АЛБА:

Гүйцэтгэх захирал

С. Эрдэнбат

Нягтлан бодогч

Б. Батхуяг

Төслийн менежер

С. Болдмаа

Төсөл хөтөлбөрийн ажилтан

Б. Сугаржаргал

БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ:

Монгол улс, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3-р баг, Голомт бизнес төв,
4 давхар 404 тоот.

Утас/Факс: 976-70533577 976-7053378

Цахим хаяг: www.goviinoyu.mn

РЕГИСТРИЙН ДУГААР:

8186995

ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Өмнөговь аймгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх сан

АЖИЛЛАГСАДЫН ТОО:

5

АУДИТОР:

"Грант Торнтон Аудит" ХХК, Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн
зөвлөгөө, сургалт, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага

Удирдлагын мэдэгдэл

Удирдлага нь санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, Байгууллагын 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусвар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн баталсан Монгол улсын Сангийн сайдын заавар, журмын дагуу зохицой толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгох, туштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн.
- Байгууллагын эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхдэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэсэн.

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ-ын УЗ-ийн дарга Тим Экерсли, Гүйцэтгэх захирал С. Эрдэнэбат болон Нягтлан бодогч Б. Батхуяг бид энэхүү тайлангийн 1-20 дугаар хуудсанд үзүүлсэн байгууллагын санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх байгууллагын санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн баталсан Монгол улсын Сангийн сайдын заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.


УЗ-ийн дарга
Тим Экерсли

Огноо:




Нягтлан бодогч
Б. Батхуяг
Огноо:

Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4	7,004,136	5,378,788
Богино хугацаат хөрөнгө оруулалт	5	1,559,256	1,130,316
Ажилчдаас авах авлага	6	2	-
		8,563,394	6,509,104
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө (цэвэр)	7	52,792	47,195
Биет бус хөрөнгө (цэвэр)	8	-	463
		52,792	47,658
Нийт хөрөнгө		8,616,186	6,556,762
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	9	2,599,954	2,973,962
		2,599,954	2,973,962
Цэвэр хөрөнгө			
Хязгаарлалтгүй нөөц			
Хуримтлагдсан үр дүн	10	6,016,232	3,582,800
		6,016,232	3,582,800
Өр төлбөр ба цэвэр хөрөнгийн дүн		8,616,186	6,556,762

Уг санхүүгийн тайланг 2021 оны 9 дүгээр сарын 10 -ны өдөр батлав:



Б. Батхуяг
Нягтлан бодогч

Энэхүү санхүүгийн байдлын тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 7-с 20 дугаар хуудсан дахь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

Үр дүнгийн тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2020	2019
Үндсэн үйл ажиллагааны орлого			
Бэлэг, хандив, тусламжийн орлого	11	14,629,916	13,162,600
Бусад орлого	12	503,711	517,780
		15,133,627	13,680,380
Үндсэн үйл ажиллагааны зардал			
Хандив, тусламжийн зардал	13	(322,596)	(349,089)
Хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	14	(138,650)	(155,558)
Төсөл хэрэгжүүлэх зардал	15	(11,639,467)	(9,637,287)
Ерөнхий удирдлагын зардал	16	(599,316)	(491,125)
		(12,700,029)	(10,633,059)
Үндсэн бус үйл ажиллагааны олз (гарз)			
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	17	(166)	-
		(166)	-
Тайлант жилийн цэвэр үр дүн		2,433,432	3,047,321

Энэхүү үр дүнгийн тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 7-с 20 дугаар хуудсан дахь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

Цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Хязгаарлалтгүй нөөц	Хуримтлагдсан үр дүн	Нийт
2019 оны 1 дүгээр сарын 01-ний байдлаар	-	535,479	535,479
Тайлант жилийн үр дүн	-	3,047,321	3,047,301
2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	-	3,582,800	3,582,780
Тайлант жилийн үр дүн	-	2,433,432	2,433,432
2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	-	6,016,232	6,016,232

Энэхүү цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 7-с 20 дугаар хуудсан дахь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2020	2019
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлого (+)	14,761,956	14,446,440	
Бэлэг, хандив, тусламж	14,616,774	13,162,600	
Бусад мөнгөн орлого	145,182	1,283,840	
Мөнгөн зарлага (-)	(13,193,741)	(15,576,008)	
Ажиллагчдад олгосон мөнгө	(183,750)	(167,162)	
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(21,650)	(42,380)	
Түвш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(11,031)	(12,841)	
Татварын байгууллагад төлсөн	(42,280)	(17,960)	
Даатгалын төлбөрт төлсөн	(97)	(116)	
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	(12,934,934)	(15,335,550)	
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,568,215	(1,129,568)	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлого (+)	-	-	
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-	
Мөнгөн зарлага (-)	(270,299)	(261,285)	
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	-	(4,400)	
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	(270,299)	(256,885)	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(270,299)	(261,285)	
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлого (+)	327,432	391,384	
Хүү ба урамшууллын орлого	327,432	391,384	
Мөнгөн зарлага (-)	-	-	
Зээл төлсөн мөнгө	-	-	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	327,432	391,384	
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,625,348	(999,469)	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4	5,378,788	6,378,257
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн лдэгдэл	4	7,004,136	5,378,788

Энэхүү мөнгөн гүйлгээний тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 7-с 20 дугаар хуудсан дахь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

Хараат бус аудиторын Үндэслэлтэй баталгаажуулалтын дүгнэлт

Далай тауэр 9 давхар, ЮНЕСКО
гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р
хороо, Улаанбаатар 14230,
Монгол улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 fl, UNESCO street,
Sukhbaatar District-1, Ulaanbaatar
14230, Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-ын удирдлагад

Цар хүрээ

Бид Төрийн бус байгууллагын 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх Төсөв, гүйцэтгэлийн тайлан (цаашид “тайлан” гэх) нь материаллаг зүйлсийн хувьд доор дурдсан нягтлах асуудал болон шалгуурт үндэслэн Баталгаажуулалтын гэрээт ажлыг гүйцэтгэсэн.

Нягтлах асуудал

Бидний баталгаажуулалтын нөхцөл нь:

- Үйл ажиллагааны зардлын Төсөв, гүйцэтгэлийн тайланда дүгнэлт өгөх
- Хандивлагч байгууллагын санхүүжилтийг холбогдох гэрээний нөхцөлийн дагуу зарцуулсан эсэхийг баталгаажуулах

Шалгуур

Баталгаажуулах гэрээт ажлыг гүйцэтгэхдээ доорх шалгуур, бусад асуудлыг үндэслэн дүгнэлтээ илэрхийлсэн. Үүнд:

- “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-ын 2020 онд хандивлагч байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилт болон түүний зарцуулалт нь хандивлагч байгууллагатай хийсэн хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хийгдсэн эсэх,
- Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт санхүүжилтийн гэрээ хийгдсэн эсэх, санхүүжилт нь гэрээнд заагдсан хуваарийн дагуу үнэн зөв хийгдсэн байдал, хүлээн авсан санхүүжилтийг гэрээнд заагдсан гүйцэтгэлийн хугацаанд заагдсан ажилд зарцуулсан байх,
- Хандивлагч байгууллагаас ирүүлсэн санхүүжилтийг Санхүүгийн удирдамжийн дагуу хуваарилан Удирдах зөвлөлөөс баталсан төсвийн хүрээнд зарцуулсан байх,
- Санхүүгийн ажил гүйлгээ нь анхан шатны баримтын шаардлагыг хангаж, бүрдэл нь иж бүрэн байх.

Удирдлагын үүрэг хариуцлага

Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн удирдлага нь хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хандивлагч байгууллагын санхүүжилтийг зарцуулж, төсөв, гүйцэтгэлийн тайлангаа үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.



Бидний хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, үүнд ёс зүйн шаардлагын нийцлийн талаарх батлагдсан бодлого, горим, мэргэжлийн стандартууд болон холбогдох хуулийн шаардлагуудыг хангаж ажилласан.

Бидний үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага нь нягтлах асуудал нь бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох шалгуурыг хангаж буй эсэхэд үндэслэлтэй баталгаа өгөх юм. Энэхүү гэрээт ажлыг Олон улсын Нягтлан бодогчдын холбооны Аудитын болон Баталгаажуулалтын олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан Баталгаажуулах гэрээт ажлын олон улсын стандарт 3000-ын дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн.

Баталгаажуулалтын түвшин

Үндэслэлтэй баталгаажуулалтын гэрээт ажил нь асуулга явуулах, шинжилгээ хийх, хяналтын тест гүйцэтгэх болон дүгнэлтийн үндэслэл болохуйц баталгаажуулалт олж авах зорилгоор хангалттай бусад нотолгоо цуглуулах горимуудаас бүрдэнэ. Гүйцэтгэх горим нь запилан эсвэл алдааны улмаас үүссэн мэдээллийн материаллаг буруу илэрхийллийн эрдэл зэрэг шалгагч аудиторын мэргэжлийн шийдлээс хамаарна. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

Гүйцэтгэсэн ажлын хураангуй

Бид дараах горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд үүгээр хязгаарлагдаагүй. Үүнд:

- Төрийн бус байгууллагын бодлого, журамтай танилцах;
- Төрийн бус байгууллагын бодлого, журамд орсон өөрчлөлтүүдийг судлах;
- Зардлын зөвшөөрөл/баталгаажуулалт болон дэмжих баримтын хүчин төгөлдөр байдлыг шалгах;
- Батлагдсан төсвийн дагуу зардлыг хуваариласан эсэхийг шалгах;
- Дансад, дэмжих баримт, санхүүгийн тайлан болон бусад тайлангийн арифметик тооцооллын үнэн зөв байдлыг шалгах;
- Төслийн үр ашигтай байдал болон нягтлан бodoх бүртгэл, санхүүгийн тайлагналын үйл явцыг баталгаажуулах;
- Батлагдсан төсөвтэй уялдуулан зардлыг баталгаажуулах;
- Зохистой бүртгэл, хөтлөлттэй байгаа эсэхийг шалгах;
- Бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын үйл явц нь Гэрээнд нийцсэн Худалдан авалтын дүрэм журмын дагуу зохистой эсэхийг шалгах;
- Өмнөх санхүүгийн шалгалтын тайлангийн үр дүнгээр илрүүлсэн асуудал, залруулга, зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг шалгах;
- Дотоод систем болон үйл явц нь зохистой бүрдсэн эсэхийг шалгаж, нотлох баримтаар баталгаажуулах.

Эдгээр горимыг асуулга явуулах, ажлын зураг авалт гүйцэтгэх, анхан шатны баримт шалгах, шинжилгээний горим гүйцэтгэх, тайлагнах бодлогын зохистой байдлыг үнэлэх, тулган баталгаажуулах зэрэг мэргэжлийн шийдэлд тулгуурлан гүйцэтгэсэн.


Баталгаажуулалтын хязгаарлалт

Гэрээт ажлын хүрээнд санхүүгийн тайлангийн энэхүү хараат бус үндэслэлтэй баталгаажуулалтын тайлан нь зөвхөн хандивлагч байгууллагад зориулан бэлтгэсэн бөгөөд өөр бусад зорилгогүй болно.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр,

- "Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ-ын 2020 оны хандивлагч байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн зарцуулалтын үйл ажиллагаа нь хандивлагч байгууллагатай хийсэн хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хийгдсэн байна.
- Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд нь санхүүжилтийн гэрээ байгуулсан ба санхүүжилт нь гэрээнд заагдсан хуваарийн дагуу хийгдэж, гүйцэтгэл нь гэрээнд заасан хугацаа болон зорилгын дагуу зарцуулагдсан байна. Тайлант оны үйл ажиллагааны зардлын төсвийн зарцуулалтаар эд хөрөнгө худалдан авах, оффисын хэрэглээний зардуудын хувьд 31.5 сая төгрөгийн хэтрэлтийг эс тооцвол үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл нь батлагдсан төсвийн дагуу зарцуулагдсан байна.
- Хандивлагч байгууллагаас ирүүлсэн санхүүжилтийг Санхүүгийн удирдамжийн дагуу хуваарилан Удирдах зөвлөлөөс баталсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
- Санхүүгийн ажил гүйлгээ нь 11.5 тэрбум төгрөгийн и-баримтгүй (2020 онд шинэчлэгдсэн татварын багц хуулийн дагуу) зарцуулалтыг эс тооцвол анхан шатны баримтын шаардлагыг хангаж, бурдэл нь иж бүрэн байна.



Улаанбаатар, Монгол улс
2021 оны 9 дүгээр сарын 10

Үйл ажиллагааны зардлын төсөв, гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Зардлын ангилал	Төсөв	Гүйцэтгэл	Зарцуулалтын хэмнэлт/ хэтрэлт	
				дүн	хувь
1.1	Хөдөлмөрийн хөлс /Цалин, даатгал/	234,834	227,927	6,908	13 <
1.2	ХДС-ийн оффисийн зардал	38,311	49,576	(11,265)	29 >
	Захиргааны зардал /Интернет, утас, шуудан/	7,365	6,601	764	10 <
	Оффисын түрээс зардал	16,988	16,988	-	-
	Хэрэгцээний зардал	13,958	25,987	(12,029)	86 >
1.3	Сурталчилгаа, хурлын зардал	188,385	96,012	92,373	51 <
	Удирдах зөвлөл, Харилцаа хорооны хуралтай холбоотой зардал	38,765	4,555	34,210	88 <
	Зарлал, сурталчилгаа, тараах материалын зардал	149,620	91,457	58,163	39 <
1.4	Бусад	58,819	33,860	24,959	42 <
	Хяналтын зардал	10,636	1,703	8,933	84 <
	Сургалтын зардал	5,000	282	4,718	94 <
	Итгэмжлэгдсэн зөвлөхийн зөвлөх үйлчилгээний зардал	8,000	8,000	-	-
	Хөндлөнгийн аудитын зардал	16,500	12,100	4,400	27 <
	Тээврийн зардал	18,683	11,775	6,908	37 <
2.1	Нэмэлт зардал (Нэг удаагийн)	155,398	146,870	8,528	79 <
	Хамтын ажиллагааны гэрээний 5 жилийн ойг угтаж зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа	155,398	127,357	28,041	92 <
	Хөрөнгө худалдан авалт	-	19,513	(19,513)	100 >
	Нийт төслийн зардал	675,747	554,245	121,502	82 <

Тэмдэглэл: Хамтын ажиллагааны гэрээний дагуу Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх санхүүжилтийн удирдамжийн “Санхүүжилтийн эх үүсвэрийг хуваарилах” зарчмын дагуу төсөвлөсөн байна. Тайлант хугацаанд оффисын хэд хэдэн үндсэн хөрөнгийн элэгдэх хугацаа дуусч ашиглах боломжгүй болж, актальсны улмаас шинээр хөрөнгө худалдан авсан, мөн тэдгээрийн дагалдах хэрэгсэл, нөөц хор зэрэг худалдан авалтууд нэмэгдсэнээс үүдэн бичиг хэргийн материалын зардалт хэтрэлт үүссэн байна.

Мөн тайлант онд Ковид-19 цар тахлаас шалтгаалан томилолт, уулзалт зэрэг үйл ажиллагаа цуцлагдсаны улмаас ихэнх зардлын хувьд хэмнэлт үүссэн байна.

Санхүүгийн тайлангийн тодруулгууд

1. Үйл ажиллагааны онцлог, өрөнхий мэдээлэл

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ нь 2013 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Монгол улсын хууль тогтоомжийн дагуу Төрийн бус байгууллага хэлбэрээр Өмнөговь аймгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор үүсгэн байгуулган, Монгол улсын бүртгэлийн албанад бүртгүүлж, 8186995 тоот регистр бүхий 64947 тоот улсын бүртгэлийн гэрчилгээг авсан.

Үндсэн үйл ажиллагаа: Хамтын ажиллагааны гэрээнд заасны дагуу "Оюу толгой" ХХК-иас тус санд олгосон санхүүжилт болон аливаа санхүүжилтийг удирдан зохион байгуулах

Дараах чиглэлээр төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, тэдгээрийг үр ашигтай, зүй зохистой удирдах зохион байгуулах зорилготойгоор үйл ажиллагаа эрхэлдэг. Үүнд:

1. Усны менежмент
2. Байгаль орчны менежмент (Нөхөн сэргээлт, биологийн төрөл зүйл болон экологийн тэнцвэрт байдал)
3. Уламжлалт мал аж ахуй ба бэлчээрийн газрын менежмент
4. Үндэсний түүх, соёл, аялал жуучлал
5. Нийгмийн суурь үйлчилгээ. (Эрүүл мэнд, боловсрол, мэргэжлийн сургалт ба хөдөлмөр эрхлэлт)
6. Орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих, тэдгээрээс бараа, үйлчилгээ худалдан авах
7. Дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төслүүд
8. Түншлэгч сумдын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэгдсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, тэдгээрийг үр ашигтай, зүй зохистой удирдах, зохион байгуулах.

2. Санхүүгийн тайлан бэлтгэх суурь

2.1 Үндсэн зарчим

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт ("СТОУС")-д нийцүүлэн баталсан Сангийн сайдын заавар, журмын дагуу бэлтгэв.

Одоогоор СТОУС ашгийн бус байгууллагын НББ-ийн хандлага болон санхүүгийн тайлангийн толилуулгын талаар тодорхой зааварчилгаа агуулаагүй байна. Ашгийн бус секторын гүйлгээг НББ-д хэрхэн авч үзэх талаар СТОУС зааварчилгаа өгөөгүй бол нягтлан бодох бүртгэлийг бодлого нь НББОУСЗ-ийн Санхүүгийн тайлагналын хүрээнд нарийвчлан тусгасан СТОУС-ын суурь үзэл баримтлалд суурилдаг.

2.2 Үйл ажиллагааны ба толилуулгын валют

Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг нь төслийн үндсэн үйл ажиллагаа болон ажил гүйлгээний эдийн засгийн бодит байдалд хамгийн тохиромжтой нөлөөлж байгаа учраас төгрөг нь уг төрийн бус байгууллагын үйл ажиллагааны валют юм.

Санхүүгийн тайлангуудын хэрэглэгчдэд хамгийн тохиромжтой гэж удирдлага үзэж байгаа учраас эдгээр санхүүгийн тайлангуудыг Монгол төгрөгөөр бүхэлтгэн толилуулна.

3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

3.1 Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс

Мөнгө ба мөнгөтэй адилтгах зүйлс нь бэлэн мөнгө ба банкинд байршиж байгаа бэлэн мөнгөнөөс бүрдэнэ. Тайлант хугацааны эцэст нэрлэсэн үнэ болон гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг тайлант хугацааны эцэст Монгол банкнаас зарласан албан ёсны хаалтын ханшаар төгрөгт хөрвүүлнэ.

3.2 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгүүдийг санхүүгийн тайланд анх өртгөөр нь хэмжинэ. Үндсэн хөрөнгийн өртөгт татвар ба буцаан олгогдохгүй татварыг багтаасан худалдан авалтын өртөг, хөрөнгийг ашиглах байршилд авчрах ба ашиглахад бэлэн болгохтой холбоотой аливаа шууд зардлууд ороно.

Үндсэн хөрөнгө нь өртгөөс дансны хуримтлагдсан элэгдлийг хассан дансны цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн.

Үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа анхны өртөг болон хуримтлагдсан элэгдлийг данснаас хасна. Мөн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба олз, гарыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно. Үүнд:

Автомашин	- 10 жил
Тавилга, эд хогшил	- 10 жил
Компьютер, түүний дагалдах хэрэгсэл	- 2 жил

3.3 Орлого

Орлогыг ТББ-ын зөвшөөрсөн санхүүжүүлэгч байгууллагын санхүүжилт, банкны хүүгийн орлого мөн бусад үндсэн бус үйл ажиллагааны орлогыг хүлээж авсан эсвэл авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Мөн орлогыг нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар хүлээн зөвшөөрнө.

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ нь Оюу толгой болон Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сумтай байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор хуанлийн жил бүр 5 сая долларын санхүүжилт хүлээн авдаг. Тус санхүүжилт нь буцах нөхцөлгүй тул байгууллага санхүүжилтийг хүлээн авсан тухай бүр орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх зарчмыг баримтална. Харин үнэ төлбөргүй, хандиваар хүлээн авсан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой орлогыг тухайн буцалтгүй тусламжийг хүлээн авсан эсвэл буцалтгүй тусламжид холбогдох нөхцөлийг биелүүлсэн үед уг бүтээгдэхүүн үйлчилгээний бодит үнэ цэнэтэй тэнцэх дүнгээр хүлээн зөвшөөрөх ба уг нөхцөл хангагдах хүртэл хойшлуулж бүртгэнэ.

"Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ-ын нийт орлогыг үйл ажиллагааны (хандив тусламжийн орлого) болон үйл ажиллагааны бус орлого гэж ангилина.

3.4 Зардал

Хөрөнгийн бууралт буюу өр төлбөрийн өсөлттэй холбоотойгоор ирээдүйн эдийн засгийн өгөөжийн бууралт гарсан ба найдвартайгаар хэмжик болох тохиолдолд зардлыг хүлээн зөвшөөрнө. Зардлыг аккруэл суурийг үндэслэн хүлээн зөвшөөрнө.

Говийн оюу хөгжлийг дэмжих сан" ТББ нь Удирдах зөвлөлийн 2018 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн №10 тоот тогтоолын дагуу тайлант жилийн санхүүжилтийг Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралын заалтуудтай уялдсан байдлаар хуваарилалтын зарчмыг баримтлан зарцуулах үүрэг хүлээнэ. Энэ тогтоолоор баталсан чиглэл болон хувь хэмжээ нь тодорхой хугацааны дараа өөрчлөгджэй болох ба өөрчлөлт нь бодлогын салшгүй нэг хэсэг байна.

Хамтын ажиллагааны гэрээний дагуу төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр байгуулсан санхүүжилтийн гэрээг байгуулж, нягтлан бодс хүртгэлд төсөл хөтөлбөрийн зардлыг аккруэл сууриар хүлээн зөвшөөрөн, гүйцэтгэгч байгууллагад өгөх өглөг үүсгэн бүртгэдэг байна. Өөрөөр хэлбэл төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон хандивын зардлыг гэрээний дагуу буцаан татах нөхцөлгүйгээр санхүүжигчид олгох нь тодорхой болсон буюу санхүүжигч төсөл, хөтөлбөр, хандив тусламжийг гэрээний дагуу биелүүлэх нөхцөлийг бүрэн хангасан үед зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

3.5 Татвар

Төрийн бус байгууллага нь ТББ-ын тухай хуулийн 4 дүгээр зүйл , 23.1 дугаар зүйл болон ААНОАТ-ын тухай хуулийн 4.1.1 дүгээр зүйл, 26 дугаар зүйлээр тодорхойлж, заасны дагуу татвар төлөгч болох бөгөөд

байгууллага нь ААНОАТ-ын тухай хуулийн 21 дүгээр зүйлд засны дагуу чөлөөлөгдхөө орлогод хамаарах, ашгийн төлөө бус байгууллага тул Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгднө.

Төлөөлөгчийн газрын ажилтнуудад олгосон цалин болон түүнтэй адилтгах орлого, бусад хувь хүнд олгосон аливаа орлогод Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу татварыг 10%-иар ногдуулан суутгаж, төсөвт шилжүүлэх үүрэгтэй.

3.6 Нийгмийн даатгалын шимтгэл

Төлөөлөгчийн газар нь Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу тус байгууллагын ажилтнуудад олгосон цалин болон түүнтэй адилтгах орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцож, төсөвт төлж, тайлагнах үүрэгтэй. Төлөөлөгчийн газрын ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэл нь эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ.

4. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Бэлэн мөнгө	654	576
Банкин дахь үлдэгдэл		
- Хаан банк 5585638858	5,294,344	4,300,576
- Хаан банк 5585644465	147,445	64,713
- Хаан банк 5585672708	16,115	5,021
- Хаан банк 5585673654	194,330	58,733
- Хаан банк 5585675200	1,219,468	949,169
- Хаан банк 5608101254	131,780	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	7,004,136	5,378,788

5. Богино хугацаат хөрөнгө оруулалт

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Хугацаатай хадгаламж - 5585675222	-	1,130,316
Хугацаатай хадгаламж - 5608103160	1,559,256	-
Богино хугацаат хөрөнгө оруулалтын дүн	1,559,256	1,130,316

Тэмдэглэл: Богино хугацаат хөрөнгө оруулалт нь хамтын ажиллагааны гэрээний дагуу “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” ТББ-ийн үйл ажиллагааныхаа хүрээнд төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх санхүүжилтийн удирдамж”-ийн 4.1-т байгуулсан “Ирээдүй хойч үеийн төлөө” зориулалт бүхий Хаан банк дахь 5585675222 тоот төгрөгийн хадгаламжийн данс нь юм. “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх санхүүжилтийн удирдамж”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-д Хойч үеийн төлөө сан, мөн Удирдах зөвлөлийн 2016 оны 9 сарын 19-ний өдрийн №05 тоот тогтооолор баталсан “Өмнөговийн ирээдүй хойч үеийн төлөө сан”-ийн журмыг тус тус үндэслэн 2016 оны 12 сарын 20-ны өдөр Өмнөговь аймгийн Хаан банкны салбарт 100,000 ам.доллартой тэнцэх хэмжээний буюу 200,498.0 мянган төгрөгийн хадгаламжийг 1 жилийн хугацаатай, жилийн 16 хувь (сарын 1.3 хувь) тооцуулж байх хадгаламжийн гэрээг байгуулсан. Талууд гэрээг жил бүр сунгальт хийж нийт 10 жилийн хугацаатай байхаар гэрээ байгуулсан байна.

Тайлант хугацаанд тус дансанд 270,299 мянган төгрөгийг хадгаламжийн эх үүсвэрт нэмж хуримтлуулж, 158,651,09 мянган төгрөгийн хадгаламжийн хүүний орлого бүртгэж, тайлант оны эцсийн байдлаар нийт 1,559,256 мянган төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл тайлагнасан.

6. Дансны авлага

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Ажиллагчдаас авах авлага	2	-
Дансны авлагын дүн	2	-

Тэмдэглэл: 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн "Ковид-19 цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай" батлагдсан тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой үссэн зөрүү байна.

7. Үндсэн хөрөнгө

Мянган төгрөгөөр	Тавилга, эд хогшил	Компьютер, дагалдах хэрэгсэл	Тээврийн хэрэгсэл	Бусад хөрөнгө	Нийт
Өртөг					
2019 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	11,360	33,944	18,000	11,494	74,798
Нэмэгдсэн	1,950	2,450			4,400
Хасагдсан	-	-	-	-	-
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	13,310	36,394	18,000	11,494	79,198
Нэмэгдсэн	-	19,513	-	-	19,513
Хасагдсан	238	23,177	-	-	23,415
2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	13,072	32,730	18,000	11,494	75,296
2019 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,262	13,272	1,799	1,728	18,061
Байгуулсан элэгдэл	1,076	9,919	1,799	1,149	13,942
Данснаас хассан	-	-	-	-	-
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2,337	23,191	3,598	2,877	32,003
Байгуулсан элэгдэл	1,302	9,492	1,804	1,152	13,750
Данснаас хассан	71	23,177	-	-	23,248
2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	3,568	9,506	5,402	4,029	22,504
Үлдэгдэл өртөг					
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	10,973	13,203	14,402	8,617	47,195
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	9,505	23,224	12,598	7465	52,792

Тэмдэглэл: Тайлант хугацаанд нийт 19,513 мянган төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг компьютер, дагалдах хэрэгслийн хамт худалдан авсан. Мөн 25,204.9 мянган төгрөгийн нэр төрөл бүхий 9 ширхэг хөрөнгөнүүдийг гүйцэтгэх захирлын 2020 оны 06 сарын 30-ны 08 тоот, 2020 оны 12 сарын 31 өдөр 15 тоот тушаалаар тус тус данснаас хассан байна.

8. Биет бус хөрөнгө

Мянган төгрөгөөр	Санхүүгийн программ хангамж	Төсөвийн програм	Нийт
Өртөг			
2019 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	990	800	1,790
Нэмэгдсэн	-	-	-

Мянган төгрөгөөр	Санхүүгийн программ хангамж	Төсөвийн програм	Нийт
Хасагдсан	-	-	-
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	990	800	1,790
Нэмэгдсэн	-	-	-
Хасагдсан	990	800	1,790
2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	-	-	-
Хуримтлагдсан хороодуулга			
2019 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	404	326	730
Нэмэгдсэн	330	266	596
Данснаас хасагдсан	-	-	-
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	734	593	1,327
Нэмэгдсэн	256	207	463
Данснаас хасагдсан	990	800	1,790
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	-	-	-
Үлдэгдэл өртөг			
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	256	207	463
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	-	-	-

Тэмдэглэл: Тайлант онд ашиглах хугацаа нь дуусч элэгдлээрээ өртөө нэхсэн 1,790 мянган төгрөгийн үнэ бүхий санхүүгийн программ болон төсвийн программыг гүйцэтгэх захирлын 2020 оны 06 сарын 30-ны өдрийн 08 тоот, 2020 оны 12 сарын 31-ний өдрийн 15 тоот тушаалуудаар данснаас хассан байна.

9. Богино хугацаат өр төлбөр

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Дансны өглөг	2,599,954	2,973,962
Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,599,954	2,973,962

Тэмдэглэл: Хамтын ажиллагааны гэрээний дагуу төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр байгуулсан санхүүжилтийн гэрээг байгуулж, санхүүгийн бүртгэлд төсөл хөтөлбөрийн зардлыг аккуруэл сууриар хүлээн зөвшөөрөн гүйцэтгэх байгууллагад өгөх өглөг үүсгэн бүртгэсэн.

10. Цэвэр хөрөнгө

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Хязгаарлалтгүй нөөц	-	-
Хязгаарлалттай нөөц	-	-
Хуримтлагдсан үр дүн	6,016,232	3,528,800
Цэвэр хөрөнгийн дүн	6,016,232	3,528,800

11. Санхүүжилтийн орлого

Мянган төгрөгөөр	2020	2019
Бэлэг, хандив, тусламжийн орлого	14,629,916	13,162,600
Нийт санхүүжилтийн орлогын дүн	14,629,916	13,162,600

Тэмдэглэл: Тусламжийн орлого данс “Оюу Толгой” ХХК нь 2015 оны 4 сарын 22-ны өдөр Өмнөговь аймаг болон Ханбогд сумтай “Хамтын ажиллагааны гэрээ”-г байгуулсан, гэрээний 8.1 дэх заалтын дагуу гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор “Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ-ыг үүсгэн байгуулж, гэрээний 8.3-т заасны дагуу “Оюу Толгой” ХХК-иас жил бүр 5,000,000 ам.доллартой тэнцэх хэмжээний төгрөгийн санхүүжилтийг олгох гэрээтэй. Гэрээний дагуу 14,616,773.8 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүртгэсэн байна.

12. Бусад орлого

Мянган төгрөгөөр	2020	2019
------------------	------	------

Хүүний орлого	503,711	517,780
---------------	---------	---------

Нийт дүн	503,711	517,780
----------	---------	---------

Тэмдэглэл: Богино хугацаат хөрөнгө оруулалтын Хaan банк дахь 5585675222 тоот төгрөгийн хадгаламжийн (жилийн 16 хувь) дансанд 176,278.98 мянган төгрөгийн хүүний орлого олсон байна. Мөн Хaan банк дахь төгрөгийн харилцах данснуудын үлдэгдэлд тооцсон 327,432.4 мянган төгрөгийн хүүний орлогыг бүртгэсэн.

13. Хандив тусламжийн зардал

Мянган төгрөгөөр	2020	2019
------------------	------	------

Хандив ба тусламжийн зардал	322,596	349,089
-----------------------------	---------	---------

Нийт дүн	322,596	349,089
----------	---------	---------

Тэмдэглэл: Хандив тусламжийн сангийн журмын дагуу Өмнөговь аймаг, сумдад тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд зориулагдсан байна. Тухайлбал: Ковид-19 өвчнөөс сэргийлэх үйл ажиллагаанд буюу 210,000 мянган төгрөг (65 хувь), Хүнсний дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 43,079 мянган төгрөг (13 хувь), Авто ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 28,016 (9 хувь), наадам тэмдэглэлт ойн хандивт 41,500 мянган төгрөг (13 хувь)-ийн тус хандив тусламж үзүүлсэн байна.

14. Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал

Мянган төгрөгөөр	2020	2019
------------------	------	------

Оюутны тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	138,650	155,558
--	---------	---------

Нийт дүн	138,650	155,558
----------	---------	---------

Тэмдэглэл: Хамтын ажиллагааны гэрээний зорилтын дагуу “Ирээдүй хойч үеийн төлөө зориулан хэрэгжүүлдэг Оюутны тэтгэлэг хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймагт дутагдалтай байгаа мэргэжлээр их дээд сургуульд амжилттай суралцаж байгаа, нийгмийн ажилд идэвхтэй санаачлагатай оролцдог нийт 47 оюутанд олгосон тэтгэлэг байна.

15. Төсөл хэрэгжүүлсний зардал

Мянган төгрөгөөр	2020	2019
------------------	------	------

Нийгмийн дэд бүтэц	8,183,605	4,832,223
--------------------	-----------	-----------

Нийгмийн суурь үйлчилгээ	2,449,147	1,822,437
--------------------------	-----------	-----------

Усны менежмент	43,824	448,901
----------------	--------	---------

Орон нутгийн бизнес хөгжил	766,416	1,400,025
----------------------------	---------	-----------

Байгаль орчны менежмент	36,835	41,717
-------------------------	--------	--------

Уламжлалт мал аж ахуй	-	843,537
-----------------------	---	---------

Үндэсний түүх соёл, аялал жуулчлал	159,640	248,446
------------------------------------	---------	---------

Нийт дүн	11,639,467	9,637,287
----------	------------	-----------

Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсний зардлыг гэрээгээр нь задалбал дараах байдалтай байна:

15.1. Нийгмийн дэд бүтэц

Гэрээний дугаар	Төсөл хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дүн
ГОХДС/2020-12	Даланзадгадын 1200 хүүхдийн сургууль	Хүннүгийн говь ХХК	4,626,167
ГОХДС/2020-09	Өмнөговь аймгийн музейн нэмэлт ажил-Интерьер, лифт, гонх	Аглут ХХК	2,089,053
ГОХДС/2020-08	Өмнөговь аймгийн музейн нэмэлт ажил-Тоног төхөөрөмж	Эрдэнийн гүн говь ХХК	493,990
ГОХДС/2020-05	Өмнөговь аймгийн музейн нэмэлт ажил-Нэмэлт ажил	Аглут ХХК	471,702
ГОХДС/2020-01	Өмнөговь аймгийн музейн нэмэлт ажил-Тоног төхөөрөмж-хорго	Тангад-Араа ХХК	137,454
ГОХДС/2020-10	Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн цогцолборийн барилга-Дээврийн нэмэлт ажил	Биндэр алтай оюу ХХК	135,800
КСМЛ/2020-02	Биесийн тамирын гадна талбай тохижуулах	Ж.Бурмаа	56,712
ГОХДС/2020-11	Ханбогд сумын цахилгаан шугамын өргөтгөл	Хуяг-Эрчим ХХК	50,000
ГОХДС/2018-34	Ханбогд сумын ерөнхий боловсролын сургууль менежмент	Ханбогд сумын ерөнхий боловсролын сургууль	45,000
КСБГ/2020-03	Нэгдсэн гудамжны гэрэлтүүлэг	Далан-Од ххк	39,500
КСБД/2020-01	Амгалан орчин	Дэт ХХК	38,227
Нийт дүн			8,183,605

15.2. Нийгмийн суурь үйлчилгээ

Гэрээний дугаар	Төсөл хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дүн
КСБО/2019-06	Тоглоомын эзэд хөтөлбөр	П.Оюу-Эрдэнэ	6,000
	Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих хамтарсан хөтөлбөр	НҮБ	1,350,729
ГОХДС/2020-07	Усан спортоор хичээллэж, биеэ чийрэгжүүлье	Цамхаг-Өргөө ХХК	231,206
КССВ/2020-01	Насан туршийн боловсрол Насан туршийн баталгаа	Ц.Сайнзаяа	8,846
КССВ/2020-02	Англи хэлтэй Сэврэйн багачууд	О.Өрнөх	2,750
КССВ/2020-04	Багийн хөгжлийн сүмын хөгжил	Ч.Наранцэцэг	5,380
КСМЛ/2020-01	Шинэ сургууль, шинэ орчин, шинэ санаачилга	Т.Энхтуул	32,350
КСМЛ/2020-04	Эмнэлгийн ариутгал халдвартгүйжүүлэлт	Д.Оюунчулуу	8,995
КСМЛ/2020-05	Дулаан байр тухтай орчин	Н.Пунцагболд	22,504
КСМЛ/2020-06	Цэвэр орчин цэмигээр байгууллага	М.Мөнх-Од	9,604
КСЦО/2020-02	Түргэн тусламжийн автомашин нийлүүлэх	Ургац капитал ХХК	23,000
КСДЗ/2020-01	Аюулгүй орчин-Амьдралын баталгаа	Говийн дөрвөлж хайрхан ХХК	36,000
КСДЗ/2020-02	Монтессорын сургалтын хэрэглэгдэхүүнээр дамжуулан хөгжүүлэх арга зүй хөтөлбөр	Ш.Гэрэлмаа	5,000
КСДЗ/2020-03	Шинэ зууны хот соёлтой иргэн	А.Жамъяндэлгэр	37,969
КСДЗ/2020-04	Эрүүл бие-Амжилтын үндэс	Т.Ууганбаяр	24,492
КСДЗ/2020-05	Эрүүл хүнс-Эрүүл бие	Ч.Дүүрэнжаргал	5,000
КСЦО/2020-01	Хамтдаа сурч, хамтдаа хөгжье	Товон Очир ХХК	15,000
КСМО/2020-01	Тоглоом-Хүүхдийн хөгжил	А.Байгальхүү	8,000
КСМО/2020-02	Цаг уурын мэдээг цагт нь	А.Ганцэцэг	4,000
КСМО/2020-03	Иргэнээ дээдэлсэн эзлтэй үйлчилгээ	Эрхэт Рай ХХК	19,850
КСДЗ/2020-06	Таван төрлийн спортоор хүүхэд залуучуудыг хөгжүүлэх	Н.Тайван-Ертэнц	24,820
КСМО/2020-05	Өөдлөх айлын ёнгө	Ивээлт тал ХХК	14,703
КСМО/2020-06	Амар тайван амьдралын орчин	Ай Ти Эс Өү ХХК	6,578
КСНМ/2020-01	Стандарт хаяг	Б.АЗбилэг	19,393
КСНМ/2020-02	Сургуулийн хашаа	Д.Ганболд	28,945
КСНМ/2020-03	Хүүхэд хөгжил	Б.Алтантуяа	15,000
КСНМ/2020-04	Малын эмч нарын цахим систем	Т.Мөнхзул	4,870

Гэрээний дугаар	Төсөл хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дун
KCHM/2020-05	Тоглоомын талбай	Х.Бат-Эрдэнэ	14,000
KCMO/2020-07	Ногоон сургууль	Хас бат мөнх ХХК	12,700
KСБГ/2020-01	ЭМТ-ийн гал тогооны тоног төхөөрөмж	Балж хөмөлийн ундарга ХХК	10,000
KСЦО/2020-03	Дотуур байрны хүүхдийн ор	Ц.Батцэнгэл	9,990
KСБГ/2020-02	Булган фитнесс төхөөрөмж	Анхсан хоршоо	7,000
KСБГ/2020-04	Монгол бичгийн кабинет тохижуулах	Логмон ХХК	6,000
KСБО/2020-01	Шуудан үйлчилгээ	Нэмэхт суурь ХХК	41,700
KСБО/2020-02	Амжилт	Нэмэхт суурь ХХК	41,700
KСБО/2020-03	Шинэ технологи, багшийн хөгжил, хүүхдийн хөгжил	Монгол мэргэд ХХК	42,000
KСХБ/2020-02	Хүүхдийн төлөө за гэж хэлцгээе	Галбын говийн гэрэлт ирээдүй ТББ	12,000
KСХБ/2020-04	Тусгай хэрэгцээ шаардлагатай бага насны хүүхдийн хөгжил	Д.Ганчимэг	24,702
KСХБ/2020-05	Тамхийг биш эрүүл мэндээ сонгөө	Э.Ундралхнаран	8,000
KСХБ/2020-06	Шүдний кабинет	Мед буян ХХК	10,000
KСХБ/2020-07	Түүхэн замнал	Б.Төмөрбаатар	20,000
KСХБ/2020-09	Ухаалаг худаг	Хандизель ОНӨААТҮГ	22,000
KСХБ/2020-10	Чавхдаст хөжимөө тоглоё	О.Төрболд	6,470
KСХМ/2020-01	Тусгай ротын хүүхдийн талбай	Б.Өлзийтогтох	7,500
KСХМ/2020-02	Хоггүй сум-Хүрмэн сум	С.Батсайхан	9,700
KСХМ/2020-03	Зөвлөн эдлэл	Б.Баяраа	6,000
KСХМ/2020-05	Дотуур байр-Бидний хөгжлийн орчин	Ц.Сүнжидмаа	20,000
KСХМ/2020-06	Эрүүл мэндийн төвийн анализатор нийлүүлэх хөтөлбөр	Нуган ХХК	16,000
KСЦО/2020-04	Эко орчинг хамтдаа бүтээцгээе	Аз билэгтэй ХХК	45,088
KСХБ/2020-11	Эрүүл хүнс хадгалалт	Ч.Мөнхбазар	27,000
KСБГ/2020-06	Дуу хөгжмийн кабинет тохижуулах	Булган лус ХХК	8,000
KСБГ, КСМЛ, КСЦО, КСБО, КСМО, KCHM, KСХБ	Эрсдэлийн сан	Өмнөговь аймгийн сумдууд	50,613
Нийт дун			2,449,147

15.3. Усны менежмент

Гэрээний дугаар	Төсөл хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дун
KCCB/2020-05	Сэврэй бэлчээр ашиглагчдын холбоо ТББ	Сэврэй сумын бэлчээр усжуулалтын ажил	23,480
KСБД/2020-03	Ган мөнх бахархал констракшн ХХК	Ухаалаг худаг	20,344
Нийт дун			43,824

15.4. Орон нутгийн бизнес хөгжил

Гэрээний дугаар	Төсөл хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дун
PN-16.2203.1-001	Өмнөговь аймгийн ЖДҮ бизнесийг дэмжих хөтөлбөр	Deutsche Gesellschaft fur internationale Zusammenarbeit (GIZ) GmbH	756,416
KСБГ/2020-05	Арьс шир боловсруулах үйлдвэр	Алтанговийн ширээ хоршоо	10,000
Нийт дун			766,416

15.5. Байгаль орчны менежмент

Гэрээний дугаар	Төсөл хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дүн
КСХБ/2020-01	Элбэг чацаргана	Ц.Мөнхчулуу	17,335
КСХБ/2020-08	Мянган мод	А.Цэцэг	18,000
КСХМ/2020-07	Ногоон хүрмэн	Г.Оюунцэцэг	1,500
Нийт дүн			36,835

15.6. Үндэсний түүх соёл, аялал жуучлал

Гэрээний дугаар	Төсөл хөтөлбөрийн нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дүн
ГОХДС/2020-03	Батмөнх даян хааныг алдаршуулах-Магтаал	Говь гурван сайхан уран бүтээлчдийн холбоо	12,400
ГОХДС/2020-02	Цамын хувцас багийг их бүрэн хийх	Өмнөговь цам сан	30,000
ГОХДС/2020-04	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын баримтат, хөрөн нэвтрүүлэг хийх	Торомгор пикчерс ХХК	10,000
КССВ/2020-03	Ёслол хүндэтгэлийн өргөө	Нүдэн булгийн өгөөж хоршоо	38,990
КСМЛ/2020-03	Зан үйлийн өргөө	Э.Мөнхсоёл	4,640
КСМО/2020-04	Өнөд дээдлэх өв соёл	Ч.Эрдэнэтоотох	9,870
КСХБ/2020-03	Ханбогд хайрхан	М.Чүлтэмсүрэн	15,000
КСХМ/2020-04	Хүрмэн гоёл	Ө.Хандсүрэн	16,240
КСБД/2020-02	Соёлын төвийн дотор тохижилт	Ундрата-Өмнөговь ХХК	22,500
Нийт дүн			159,640

16. Ерөнхий ба удирдлагын зардал

Мянган төгрөгөөр	2020	2019
Зар сурталчилгааны зардал*	218,814	106,167
Цалин хөлс, шагнал	202,520	201,829
Татварын зардал**	50,371	-
Нийгмийн даатгалын шимтгэл	25,406	25,132
Зөвлөх үйлчилгээний зардал	20,100	27,600
Түрээсийн зардал	16,988	17,038
Бичиг хэргийн зардал	16,488	8,684
Элгэгдлийн зардал	14,213	14,538
Хангамжийн материалын зардал	7,370	4,644
Шатахууны зардал	6,023	10,884
Шуудан, холбооны зардал	5,358	4,261
Сэлбэг, багаж хэрэгслийн зардал	5,341	6,489
Удирдах зөвлөл, ХХ хуралтай холбоотой зардал	4,555	28,435
Албан томилотлын зардал	1,414	1,600
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	1,115	512
Банкны шимтгэлийн зардал	1,014	557
Сонин сэтгүүл захиалгын зардал	804	994
Засвар үйлчилгээний зардал	440	1,952
Хяналтын зардал	290	3,868
Сургалтын зардал	281	5,008
АТБӨЯТХ -ийн татварын зардал	141	142
Даатгалын зардал	97	116
Бусад зардал	173	20,675
Нийт дүн		
	599,316	491,125

Тэмдэглэл: Үйл ажиллагааны зардлын жилийн нийт төсөв нь тухайн жилийн нийт санхүүжилтийн 5 хувь хүртэл гэж заасны дагуу Удирдах хорооны 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн №16 тоот тогтоолоор тайлант оны төсвийг баталсан бөгөөд зарцуулалт тус төсвөөс хэтрээгүй байна.

* Тайлант онд байгууллагын таван жилийн ой тохиосон бөгөөд олон нийтэд байгууллагаа сурталчлах, үйл ажиллагаагаа таниулах зорилгоор контент бүтээлгэх 118 сая төгрөгийн гэрээт ажил хийгдсэнээр зар сурталчилгааны зардал ёссөн байна.

** Мөн тайлант оноос эхлэн татварын хуулийн шинэчлэлтэй холбогдуулан БХХО-ын банкны хадгаламжийн хүүний орлогоос суутгуулсан татварын зардал гарсан байна.

17. Үндсэн хөрөнгө борлуулсны олз(гарз)

Төгрөгөөр	2020	2019
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	166	-
	166	-

Тэмдэглэл: Тайлант хугацаанд эвдэрч гэмтсэн, цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг данснаас хасах үед үүссэн гарз байна.

18. Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ

Тайлант хугацаанд тус байгууллага нь дараах ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн бөгөөд тайлант хугацааны эцсээр дараах үлдэгдэлтэй байна.

Холбоотой талуудын нэр	Харьялал	Хамаарал	Ажил гүйлгээ	2020
"Оюу Толгой' ХХК	Монгол улсын хуулийн этгээд	Үүсгэн байгуулагч	Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт	14,629,916
Өмнөговь аймаг, Ханбогд сум бусад түншлэгч сум	Монгол улсын хуулийн этгээд	Хамтын ажиллагааны гэрээний дагуу удирдан зохион байгуулагчид	Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хандив, дэмжлэг	-
Тим Экерсли	Австрали улсын иргэн	Удирдах зөвлөлийн дарга	Хурал, уулзалт	-
Х.Сугир	Монгол улсын иргэн	Удирдах зөвлөлийн гишүүн	Хурал, уулзалт	-
Н.Наранбаатар	Монгол улсын иргэн	Удирдах зөвлөлийн гишүүн	Хурал, уулзалт	-
Б.Эрдэнэ-Очир	Монгол улсын иргэн	Удирдах зөвлөлийн гишүүн	Хурал, уулзалт	-
Деррик Хансен	Австрали улсын иргэн	Удирдах зөвлөлийн гишүүн	Хурал, уулзалт	-
Д.Амарбаясгалан	Монгол улсын иргэн	Удирдах зөвлөлийн гишүүн	Хурал, уулзалт	-
Г.Сугар	Монгол улсын иргэн	Удирдах зөвлөлийн гишүүн	Хурал, уулзалт	-
С.Эрдэнэбат	Монгол улсын иргэн	Гүйцэтгэх захирагал	Цалин хөлс	84,962

19. Болзошгүй өр төлбөр

2020 оны жилийн эцсийн байдлаар өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэлээр хүлээсэн ямар нэг үүрэг хариуцлага байхгүй.

20. Балансын дараах үйл явдал

Байгууллагын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн тайлагналын өдрөөс хойш 2021 оны 09-р сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд санхүүгийн тайланд нөлөөлөх аливаа үйл явдал тохиолдоогүй байна.

21. Орчуулга

Эдгээр санхүүгийн тайланг Монгол, Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд тэдгээр хувилбар хооронд зөрүү гарвал, Монгол хувилбарыг дагах болно.